

Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээний хүчинтэй байх хугацаатай холбогдуулан шинээр хэрэгжүүлэх арга хэмжээ



2021 оны 7 сарын 5-ны өдөр
Хилийн шалган нэвтрүүлэх,
оршин суух хяналтын газар
Immigration Services Agency of Japan

Үндсэн чиглэл

© Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газарт өнөөг хүртэл шинэ COVID-19 халдварын тархалтаас болж Япон улсын хилээр нэвтрэн орох хугацаанаас хоцорч байгаа хүнд зориулж хилээр нэвтрэн ороход шаардах оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ(үүнээс доош “зөвшөөрлийн гэрчилгээ” гэнэ)-ний хүчинтэй хугацааг сунгах арга хэмжээг авсаар ирсэн юм(доорх “Өнөөг хүртэл хэрэгжүүлж байсан арга хэмжээ”-г харна уу).

©Энэ удаад урьдын адил COVID-19 халдварын тархалтаас шалтгаалж хилээр шалган нэвтрэх ажилд бэрхшээл үүсэж байгааг харгалзан үзэж доорх тэмдэглэгээний дагуу **зөвшөөрлийн гэрчилгээний хүчинтэй хугацааг дахин сунгуулах арга хэмжээг авах** болно(доорх “Шинээр хэрэгжүүлэх арга хэмжээ”-г харна уу).

※Мөн зөвшөөрлийн гэрчилгээ нь хилээр нэвтрэн орох нөхцөл хангагдсаныг гэрчлэх бөгөөд, хүчинтэй хугацааг хэтэрхий удаавал хилээр нэвтрэн орох үеийн байдал нь зөвшөөрлийн гэрчилгээ олгосон үеэс өөрчлөгдөх магадлал ихсэх тул доорх шинээр хэрэгжүүлэх арга хэмжээнээс хойш зөвшөөрлийн гэрчилгээний хүчинтэй хугацааг дахин сунгуулах боломжгүй боловч, **өмнөх мэдүүлгийн агуулгаас өөрчлөгдөөгүй ба 2022 оны 7 сарын 31-ний өдрөөс хойш Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газраас заасан өдөр нь хүртэл зөвшөөрлийн гэрчилгээ хүсэх мэдүүлгээ өгөх тохиолдолд (1) Олгогдсон зөвшөөрлийн гэрчилгээ(эх хувь эсвэл хуулбар) болон (2)Хүлээж авах байгууллага гэх мэтийн учир шалтгааны тайлбар бичгийг бүрдүүлснээр хурдан шинэ зөвшөөрлийн гэрчилгээг олгох** болно. Дэлгэрэнгүйг [эндээс](#) харна уу.

Өнөөг хүртэл хэрэгжүүлж байсан арга хэмжээ

Шинээр хэрэгжүүлэх арга хэмжээ

(1) Хамрагдах оршин суух статус
Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээтэй холбогдох оршин суух бүх статус

(1) Хамрагдах оршин суух статус
Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээтэй холбогдох оршин суух бүх статус

(2) Хамрагдах бүс нутаг
Бүх улс, бүс нутаг

(2) Хамрагдах бүс нутаг
Бүх улс, бүс нутаг

(3) Хамрагдах оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ
2019 оны 10 сарын 1-ны өдрөөс хойш олгогдсон

(3) Хамрагдах оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ
2020 оны 1 сарын 1-нээс хойш бүтээгдсэн

4) Хүчинтэй байх хугацаа
• **Олгосон огноо 2019 оны 10 сарын 1-нээс 12 сарын 31-ний өдөр**
→ **2021 оны 4 сарын 30-ны өдрийг хүртэл**
• **Олгосон огноо 2020 оны 1 сарын 1-нээс 2021 оны 1 сарын 30-ны өдөр**
→ **2021 оны 7 сарын 31-ний өдөр хүртэл**
• **Олгогдсон огноо 2021 оны 1 сарын 31-нээс ~**
→ **Олгосон өдрөөс эхлэн “6 сарын дотор” хүчинтэйд тооцно**

(4) Хүчинтэй байх хугацаа

• **Олгосон огноо 2020 оны 1 сарын 1-нээс 2021 оны 7 сарын 31-ний өдөр**
→ **2022 оны 1 сарын 31-ний өдрийг хүртэл**
• **Олгосон огноо 2021 оны 8 сарын 1-нээс 2022 оны 1 сарын 31-ний өдөр**
→ **Олгосон өдрөөс эхлэн “6 сарын дотор” хүчинтэйд тооцно**

(5) Хүчин төгөлдөр гэж үзэх нөхцөл
Зорчиж буй газрынхаа консулын газарт визийн мэдүүлэг өгөх үед, хүлээн авах байгууллага зэргээс “Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ авах үед мэдүүлсэн үйл ажиллагааны агуулгын дагуу үргэлжлүүлэн хүлээн авах боломжтой” гэдгийг бичсэн баримт бичиг ирүүлсэн тохиолдолд

(5) Хүчин төгөлдөр гэж үзэх нөхцөл
Зорчиж буй газрынхаа консулын газарт визийн мэдүүлэг өгөх үед, хүлээн авах байгууллага зэргээс “Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ авах үед мэдүүлсэн үйл ажиллагааны агуулгын дагуу үргэлжлүүлэн хүлээн авах боломжтой” гэдгийг бичсэн баримт бичиг ирүүлсэн тохиолдолд
[Лавлагааны маягт <Хавсралт 1 дээрх оршин суух статус>\(Жишээ: Техник хүмүүнлэг олон улсын үйл ажиллагаа, оюутан г.м\)-ын зориулалттай>](#)
[Лавлагааны маягт <Хавсралт 2 дээрх оршин суух статус>\(Жишээ: Япон улсын иргэний гэр бүл, байнгын оршин суугч г.м\)-ын зориулалттай>](#)
※ Хүсэлт гаргаснаас 3 сар өнгөрсөн тохиолдолд дахин шинээр дээрх бичиг баримтыг бүрдүүлнэ үү.